

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОРИХ БАЙГУУЛЛАГАД АШИГЛАЖ БУЙ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

GUARD PROTECTION EQUIPMENT USED IN PRISON INSTITUTIONS OF SOME FOREIGN COUNTRIES AND ITS CHARACTERISTICS



З.Юнрэн

*Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн албаны сургуулийн магистрант, дэслэгч*

Товч утга: Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдолд байнгын хяналт тавьж дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх учиртай. Техник технологийн хөгжлийн явцад хяналт улам боловсронгуй болж дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсээр байна.

Өгүүлэлд хорих байгууллагад ашиглаж буй хяналтын техник хэрэгслийн талаар судлан үзсэн.

Түлхүүр үгс: Хорих байгууллага, хоригдол, техник хангамж.

Abstract: During the process of serving a prison sentence, the prisoner should be constantly monitored to prevent reoffending and violations. In the process of technical and technological development, control has become more sophisticated, and advanced techniques and technologies are being introduced into the operation.

The article examines the control equipment used in prisons.

Keywords: Prisons, prisoners, hardware.

Дэлхийн улс орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт нь өөрийн үүсэл хөгжлийн түүхэн үе шатыг туулан улам боловсронгуй болгох чиг хандлага руу явсаар байна. Хэдийгээр улс орон бүр түүх, ёс заншил, нийгмийн байдал, эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалан хууль тогтоомжийн хөгжилт, хэрэгжүүлэх үйл явц өөр өөр боловч хөгжлийн чиг хандлага нь хүний жам ёсны эрхийг хангах, хууль дээдлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй

болгох гэсэн нэгэн зорилго, зарчимд тулгуурлан үйл ажиллагаа явуулж байна.

Өндөр хөгжилтэй орнуудын хорих байгууллага нь харуул хамгаалалт, хяналтын зохион байгуулалтын тал дээр өргөн, олон талт, маш их туршлага байгааг тэмдэглэх нь зүйтэй. Хорих байгууллагын харуул хамгаалалт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах үндсэн чиглэлүүдийн нэг бол техникийн тоног төхөөрөмж, галт зэвсэг, харуул хамгаалалтын тоног төхөөрөмжийг сайжруулах явдалд анхаардаг бөгөөд эдгээр байгууллагууд нь харуул хамгаалалтдаа үргэлж чухал ач холбогдол өгдөг байна.

Манай Улсын эрүүгийн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шинжлэх ухаанд эрх зүйн систем, эрүүгийн ял, ял эдлүүлэх ажиллагааг харьцуулан судлахад чиглэсэн харьцуулсан судлалд ач холбогдлыг өгдөг юм. Харьцуулан судлах аргын практик ач холбогдол нь бидний судалж байгаа сэдвийн хувьд маш чухал бөгөөд гадаадын орны сайн туршлагыг судлан Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэхэд оршиж байна.

Монгол Улс нь ял эдлүүлэх ажиллагааг олон улсын стандартад бүрэн нийцүүлэхийн тулд тус баримт бичгүүдэд заасан шаардлагыг биелүүлж, ял эдлүүлэх ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх нь чухал юм.

Хорих байгууллагын техникийн хангамжийг тогтмол сайжруулж шинэчлэх нь гадаадын орнуудын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны голлох чиглэл байдаг. Харьцуулсан судалгааны хүрээнд бид хэд хэдэн орны хорих байгууллагад ашиглагдаж буй техник хэрэгслийн талаар судлан үзье.

Америкийн Нэгдсэн Улс.

Америкийн Нэгдсэн Улсын хорих ял эдлүүлэх тогтолцоонд шоронгууд нь Нээлттэй хорих (minimum-security); завсрын хорих (medium-security); хаалттай хорих (closed); онцгой /хаалттай/ хорих (maximum-security) байгууллагуудад хуваагддаг.

Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, тэнд хоригдогчид гадны байгууллагад хүртэл хөдөлмөр эрхлэх боломжтой байна. Нээлттэй дэглэмд хорих ял эдлэгсдийн эрхэлдэг хөдөлмөрийн гол чиглэл нь барилга байгууламж барих, зам засах, хөдөө аж ахуйн болон бусад ажил байдаг. Энэ зэрэглэлийн шоронгууд нь хашаагаар хүрээлэгдсэн, зэвсэглэсэн харуулын постгүй, дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг. Улсын хэмжээнд гурван шоронгийн нэг нь энэ зэрэглэлд хамаардаг боловч нийт

хоригдлуудын 12 хувь нь л ийм төрлийн шоронд хоригддог гэсэн тооцоо гарчээ.

Завсрын хорих (medium –security) шоронгуудад зэвсэглэсэн хамгаалалттай, өндөр хашаагаар хүрээлэгдсэн байдаг.

Хаалттай хорих анги нь: Энэ зэрэглэлд хамаарах шоронгууд зэвсэглэсэн хамгаалалттай дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн байдаг. Байшин барилгын хувьд янз бүр, 150 шахам ганцаарчлан хорих өрөөнүүд бүхий барилгууд байдаг. 1984 оны байдлаар улсын хэмжээнд нийт шоронгуудын 40 хувь нь энэ зэрэглэлд хамаардаг ба нийт хоригдлуудын 44 хувь нь энэ төрлийн шоронгуудад ял эдэлдэг байжээ.

Хаалттай хорих анги /maximum/ нь онц аюултай гэмт хэрэгтнийг хорьдог өндөр хана бүхий хамгаалалттай байдаг ажээ. Тэнд хоригдогчдыг гадагш гарч ажиллахыг хориглоно. Энэ нь дээд зэргийн харуул хамгаалалттай шорон. Энэ зэрэглэлийн шоронгууд нь гадуураа 18-25 фут /6-8 метр/ өндөртэй хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ажиглалтын цамхаг дээр зэвсэглэсэн харуултай байдаг ба хоригдлын байр нь томоохон барилга байгууламжаас бүрддэг. Хоригдлууд нь тус тусын өрөөтэй байна. Ихэнх дээд зэрэглэлийн хамгаалалттай шоронгууд 19 дүгээр зууны эхэн үед баригдсан байдаг ба олонх гэмт хэрэгтнүүд энэ шоронд хоригдож байжээ. 1984 оны байдлаар Америкийн Нэгдсэн Улсын хэмжээнд дөрвөн шоронгийн нэг нь энэ төрлийн (дээд зэргийн хамгаалалттай) шорон байсан ба нийт хэрэгтнүүдийн 44 хувь нь энэ төрлийн шоронд хоригдож байна гэсэн тооцоо гарчээ. Хорих ангийн удирдлага хорих ял эдэлж буй хүн бүрийг хэрхэн удирдах, хоригдол бүрийн хорих ангид ба нийгэмд ямар эрсдэл учруулж болохыг нээн илрүүлэх чадавхтай байхыг шаарддаг.

Энэ шоронд инженер, техникийн хэрэгслийн тусламжтай зургаан харуул хамгаалалтын бүсийг бүрдүүлсэн байна. Харуул хамгаалалтын найдвартай байдлыг хангахын тулд корпус тус нь ойртуулах, бичлэг хийх боломжтой 500 камерыг суурьлуулах ёстой байдаг. Телекамын хяналтын төв нь тусдаа барилгад байралдаг. Хяналтын компьютер дээр тасралтгүй хяналтын зэрэгцээ камерын гэрэл асаах, унтраах, ул гоожуулах, усны хоолойг нээх, хаах цэс байдаг байна.

Ричард Тьюксбури. Хорих анги дахь өөрчлөлт, шинэчлэл¹/өнгөрсөн 10 жилд/: 21 зууны эхний 10 жилийн хугацаанд хорих байгууллагын үйл ажиллагаанд дараах үндсэн өөрчлөлт хийгдсэн байна. Хоригдлын тоо өссөн ба түүнтэй холбоотойгоор түүний хувьсах зардал нэмэгдсэн, олон нийтийн зүгээс аюулгүй байдлыг чангатгах шаардлага ихэссэн, ба мэдээлэл харилцаа холбооны шинэ технологийн нөлөө нэмэгдсэн байна.

Хаалттай хорих /онцгой/ (Super-max Prison): Олон нийтийн зүгээс эрүүгийн хуулийг чангатгах нь зүйтэй гэсэн үзэл санаа нийгэмд давамгайлж, хорих байгууллагыг удирдах газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Хорихын дотоод аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал: Онц аюултай хоригдлын хорих нөхцөлийг улам чангатгах үйл ажиллагааг явуулж хаалттай хорих /онцгой/ ангиудыг байгуулсан. (super-max prison). Шинэ зууны эхний 10 жилд нийтдээ 44 хаалттай хорих /онцгой/ байгуулагдсан байна. Эдгээр хорих ангид хоригдлуудад чиглэгдсэн сургалтын хөтөлбөрүүд үндсэндээ байдаггүй.

Холбооны хорих байгууллагуудыг удирдах газар (Bureau of Prisons-шоронгийн товчоо) ба хорих ангиуд (Institutions): Холбооны хорих байгууллагуудыг удирдах газар нь хорих ангиудыг доорх шинжээр хуваан үздэг. Үүнд: Аюулгүйн зэрэглэл буюу дэглэм нь эргүүл хамгаалалтын ажилтан, цамхаг, хяналтын хэрэгсэл, хоригдлуудын байрны нөхцөл ялгаа, хоригдол ба албан хаагчдын зохистой харьцаа зэрэг юм.

Нээлттэй хорих анги (Minimum Security institutions): Хоригдлууд нийтийн байранд байрлах, албан хаагч-хоригдлын харьцаа хамгийн бага хамааралтай, хязгаарлагдмал аюулгүйн бүстэй бөгөөд ихэвчлэн цэргийн анги юм уу өөр нэг байгууллагын хажууд байрладаг.

Аюулгүйн дунд түвшинтэй хорих анги (Low Security Federal Correctional institutions) нь давхар хамгаалалтын хашаатай, хоригдлууд нийтийн байранд байхаас гадна олон төрлийн сургалт, хөтөлбөрт хамрагддаг. Албан хаагч болон хоригдлын хамаарал илүү нягт байна.

¹ Richard Tewksbury. Prisons in the Last Ten Years, Victims & Offenders, DOI: 10.1080/15564886.2010.485905 .PP. 242-243. (2010)

Аюулгүй байдлын завсрын түвшинтэй хорих байгууллага (Medium Security) давхар хашаатай, цахилгаан гүйдэлтэй бүс, хоригдлууд тусгаар өрөөнд байрлахаас гадна дотоод хяналт маш хүчтэй байдаг.

Хаалттай буюу аюулгүй байдлын өндөр түвшинтэй хорих байгууллагууд (High Security institutions): Өндөр хэрмэн ханатай, хоригдол ганцаарчилсан өрөөнд байрлах, хоригдлын үйл ажиллагаа бүрэн хянагдсан, албан хаагч-хоригдлын зохистой харьцаатай.

Холбооны Цогцолбор Хорих Байгууламж (Federal Correctional Complexes): Өөр өөр бүтэц, дэглэмтэй хорих анги нэг байгууламжид байх бөгөөд ач холбогдол нь өөр хоорондоо мэдээлэл, үйлчилгээ солилцоход оршино.

Холбооны захиргааны Байгууламж (Administrative facilities): үндсэн чиг үүрэг нь сэжигтэнг урьдчилан хорих, архаг өвчтөн, онц аюултай хоригдлуудыг дэглэм харгалзахгүйгээр тусгаарлан байрлуулах ба үүнд хотын урьдчилан хорих байр, дамжин өнгөрүүлэх байр, хорих байгууллагын эмнэлэг хамаардаг.

АНУ-ын хорих байгууллагуудад цахилгаанжуулсан хязгаарлалтын хашааг өргөнөөр ашигладаг. АНУ-ын харуул хамгаалалтын чиг үүрэг бүхий шоронгийн алба хаагчид галт болон химийн (нулимас асгаруулагч), бороохой, номхруулагч цамц болон бусад техник, хэрэгсэл ашиглах боломжтой байдаг. Тэдэнд зориулан хоригдлуудтай харьцахдаа дагаж мөрдөх зан байдал, зан үйлийн заавар боловсруулагдсан байдаг бөгөөд тус баримт бичигт зөвхөн эрх зүйн бус өөрийгөө хамгаалах сэтгэл зүйн онцлог, биеийн хүч ашиглах зэргийг тусгасан байна. Хамгийн чухал нь алба хаагчдын зүгээс хоригдолд хэрэглэж байгаа санкци нь тэдний гаргасан хууль бус үйлдэлд оногдуулах арга хэмжээнд таарсан байх ёстой юм.

АНУ болон бусад арав гаруй орнуудад хоригдлын биометрын адилтгалыг ашигладаг байна. АНУ-ын шоронгуудад хоригдлын анкетын мэдээлэл, нүд, хурууны хээг агуулсан мэдээллийн сан байдаг.

Биометрийн адилтгал нь хяналт тавих, хувь хүний онцлог шинжийг тусламжтайгаар түүнийг таних үр дүнтэй хэрэгслийг нэг юм.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс бол ял эдлүүлэх шинжлэх ухааны дэлхийд алдар нэрээ дуурсгасан эрдэмтэн Дж.Говард /1726-1790/, И.Бентам /1748-1832/ нарын эх орон юм.

Эдгээр эрдэмтэн тухайн үедээ ял эдлүүлэх чиглэлээр сонирхолтой төслийг нийгэмд санал болгосон юм. Тэдний санал, санаачилгын үндсэн агуулга нь ял эдлэгчдийг хөдөлмөр, сургалт хосолсон ажиллагаанд хамруулж, ерөнхий боловсролын сургалтад оролцуулах, ингэснээр тэднийг гэмт хэргийн ертөнцөөс ангижруулахад чиглэж байв.

Эрдэмтдийн шинэ санал нь нийгмийн амьдралаас хол хөндийд тооцогдон тухайн үедээ хэрэгжих боломжоор хангагдаагүй байна. Гэвч шинэ дэвшилтэт үзэл санаа нь Английн төдийгүй дэлхий нийт, ялангуяа Орос улсын ял эдлүүлэх ажиллагааны хөгжилтөд шинэ хүч өгсөн гэж үздэг.

XIX зуунд Англи улсын хорих ял эдлүүлэх ажиллагаанд ноёлж байсан удаан хугацаагаар ганцаарчлан хорих байдлыг өөрчлөн хэсэг бүлгээр нь хорих хэлбэрт шилжиж эхэлсэн байна.

Хоригдлын ял эдлэх нийт хугацааг:

а/ туршилтын буюу ганцаарчлан хорих, албадан хөдөлмөрлүүлэх;

б/ хугацаанаас өмнө тэнсэн суллах /нийт ялын дөрөвний гурвыг эдэлсэн бол/ гэж хувааж байв.

Дээрх хоёр үе шатны хооронд завсрын буюу хагас чөлөөтэй байх, ял эдлэгчдийг харуул хамгаалалтгүйгээр ажиллуулах, гадаад орчинтой чөлөөтэй харилцдаг байх саналыг эрдэмтэн В.Крофт дэвшүүлжээ. Энэ завсрын үе шатны ажиллагаа хэрэгжин, хоригдлыг нийгэмшүүлэхэд үр дүнгээ өгөх болсон байна. 17-21 насны ялтныг хорьж ялыг нь эдлүүлэх “Бростал” /хотын нэр/ системийн тухай дэлхийн олон улс орон мэдэх болов. Бростал хотын ял эдлүүлэх хүмүүжлийн байгууллагад 6 сараас 2 жил хүртэлх хугацаанд ял эдлэгчдийг хорьж тэднийг албадан хөдөлмөрлүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтад хамруулж байв.

Англид нэрд гарсан ял эдлүүлэх тусгайлсан дэглэм бүхий байгууллага бий болоход нэг талаар нэрт эрдэмтэн Д.Говард, И.Бентам нарын санаачилга, нөгөө талаар Залуучуудад зориулагдсан Америкийн дэвшилтэт шоронгийн үлгэр дууриал нөлөөлсөн гэж үздэг.

Англи улсын ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ.

Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Түүнчлэн:

а/ богино хугацаагаар хорих ял эдлэгчид

б/ торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгчид

в/ 21 хүртэлх насны залуучууд хоригддог байна.

Эдгээр төрөлд ял эдлэгчдийн үйлдсэн гэмт хэргийн байдал, засралын түвшинг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам үйлчилдэг.

1969 оноос эхлэн Англи улсын хорих ял эдлүүлэх төвлөрсөн байгууллага нь хугацааны хувьд:

а/ богино хугацаатай буюу 18 сар хүртэл;

б/ дунд хугацаатай буюу 1,5-5 жил хүртэл;

в/ урт хугацаатай буюу 5 жилээс дээш хугацаатай гэж ангилсныг хорих ял эдлүүлэх ажиллагаанд ялгавартай хандах, зохих үр дүнд хүрэх ач холбогдолтойд тооцдог байна.

Хэдийгээр төвлөрсөн ял эдлүүлэх байгууллагыг дээрх байдлаар ангилдаг ч үндсэнд нь нээлттэй ба хаалттай гэж хуваадаг.

Нээлттэй байгууллагад зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр торгүй бөгөөд тэнд хоригдон ял эдлэгчид өөр байгууллагад очиж хөдөлмөрлөж болдог. Ийм хэлбэрийн байгууллага цөөн байгаа ч цаашид олшруулах чиглэл баримталдаг ажээ.

Хаалттай шорон нь зэвсэглэсэн харуул, өндөр, бөх бат хана зэргээр нийгмээс хатуу тусгаарлагдсан байдаг онцлогтой.

Их Британийн хорих байгууллагуудад харуул хамгаалалтыг байгууллагын хэрмэн хашааны эргэн тойронд байрлах өргөн хүрээний камерын тоног төхөөрөмж ашиглан аюулгүй байдлын ажилтнууд нь хяналт тавьж үүрэг гүйцэтгэдэг. Техникийн тусламжтайгаар хамгаалагдсан объектын хязгаарлагдмал бүс рүү иргэд нэвтрэх талаар алба хаагчид нь урьдчилан мэдэж сэрэмжлүүлэх боломжтой. Хорих байгууллагуудын үндсэн хашааны дээд хэсэгт тусгай хамгаалалтын тог дамжуулагч байдаг бөгөөд энэ нь харуул хамгаалалтад хоригдолуудыг оргохоос урьдчилан сэргийлэх томоохон арга хэмжээ болдог байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Энэ улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад 1975 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хууль, 1976 онд батлагдсан Хорих ял эдлүүлэх болон засрал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай хууль тус тус хамаарна.

Хорих болон торгох ял оногдуулах, түүнчлэн засрал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зэрэг нь тус тусдаа өөрийн онцлогтой.

ХБНГУ-ын эрүүгийн ял оногдуулалтад торгох ял хамгийн өргөн хэрэглэгддэг. Торгох ял нь 5-360 өдөр байх ба торгуульд хамруулах цалингийн хэмжээг шүүх тогтоодог байна. Ингэхдээ өдөрт ногдох цэвэр орлогоос тооцдог бөгөөд торгуулийн нийт хэмжээ нь 2-10 мянган марк байна.

Хорих ял нь 1 сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорих хугацаатай. Бүх насаар нь хорих гэдэг нь харьцангуй ойлголт юм. Хоригдол 15-аас доошгүй жил ял эдэлсний дараа түүний үлдсэн ялыг зохих нөхцөлтэйгээр хойшлуулж болдог байна.

ХБНГУ-д хорих ял эдлүүлэх ажиллагааг дэглэмийн төрлийн хувьд нээлттэй ба хаалттай гэсэн хоёр хэлбэрээр эдлүүлдэг байна.

Нээлттэй хорих байгууллагад 6 сар хүртэл богино хугацаагаар хорих ял шийтгүүлэгчид, эсхүл үйлдсэн гэмт хэргийн хор аюул нь бага хоригдлын ялыг эдлүүлнэ. Харин нээлттэй хорих байгууллагын тоо нь харьцангуй цөөн байдаг.

Хаалттай хорих байгууллага нь ХБНГУ-ын ял эдлүүлэх байгууллагын үндсэн төрөл бөгөөд тооны хувьд ч олон байдаг ажээ.

Дээрх хоёр дэглэмийн агуулга, хэрэгжилтийн байдлыг Ремшайдын нээлттэй¹, Хаган², Вуфпертал³ дахь хаалттай хорих ангийн жишээнээс харж болно.

Насанд хүрсэн бүх хоригдол зургаан сараас дээш хугацааны хорих ял шийтгүүлсэн бол эхлээд ганцаарчилсан тасалгаанд байж шоронгийн амьдралтай танилцдаг байна. Энэ хугацаанд ял эдлэгсдийн дэглэм,

¹ Пүрэвсүрэн, О. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. 45 дахь тал. УБ. 2014

² Мөн тэнд. 58 дахь тал

³ Танилцуулгын материал. Justizvollzugsanstalt Wuppertal 01.01.2000

хөдөлмөр зохион байгуулалт, сургалт, хүмүүжлийн ажлыг цаашид хэрхэн зохион байгуулахтай холбогдсон судалгаа хийгдэнэ.

Харин хаалттай дэглэмд ял эдлүүлэхдээ нээлттэй дэглэмийн ялтнуудтай харьцуулбал эрх нь илүү хязгаарлагдмал шинжтэй боловч ялтны ахуй хангалт, орон байр, хувцас, хоол хүнсний хангалтууд адил байдаг ажээ.

Хаалттай хорих анги нь өндөржүүлсэн хамгаалалттай, ялтны өрөө нь бие засах газар, угаалтуур, ахуйн хэрэглээний зүйл тавих тавиур, бичгийн ширээ, сандал, номын тавиур, радио телевизээр тоноглогдсон байдаг. Тэд зураг зурах, мужаан, тавилгын үйлдвэрлэл, гутал болон оёдлын бүтээгдэхүүн, хүүхдийн тоглоом, угаалга хими цэвэрлэгээ, авто машины зарим төрлийн сэлбэг хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл засвар зэрэг ажлыг хийдэг. Энэ дэглэмд ялтны ялыг эдлүүлэхдээ доод, дунд, дээд гэсэн 3 нөхцөл байх бөгөөд нөхцөлөөсөө шалтгаалж ялтны эрх, ахуй хангалт, дэглэм тодорхойлогддог. Ялтнууд цулгай нэг өнгийн, харин онц аюултай гэмт хэрэгтэн нь эрээн хувцас өмсдөг байна.

Вуфпертал дахь хаалттай хорих анги 1980 онд нээгдсэн бөгөөд нийт 495 хүний /хоригдол/ багтаамжтай ганцаарчлан хорих 394 хүний өрөөтэй байна. Хамгаалалтын хашаа нь 4 м өндөр, 840 метрийн урттай, хашаанд суурилсан гадна дотор талыг харах боломжтой, телекамер, холбоо дохиоллын хэрэгслээр тоноглогдсон 4 ширхэг харуулын посттой, хашааны дотор 47250 метр квадрат талбайтай байна.

Баден-Вюртемберг холбооны мужид байрладаг урьдчилан хорих байранд аюулгүй байдлыг зохион байгуулж байсан туршлага сонирхолтой байна. Тус байгууллага нисэх онгоц ашиглан зугтах аас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авчээ. Урьдчилан хорих байрны хэрмэн хаашааны дэвсгэрт эсрэг харалдаа хашаа хүртэл дээрх цамхаг хүртэл сунгасан кабелийн цахилгаанжуулсан системээр хаасан байна.

Харуул хамгаалалтын цамхаг дээр хоёр ажилтан байрлуулах замаар байгууламжийн аюулгүй байдлыг хангадаг. Энгэснээр тус урьдчилан хорих байр нь хориотой бүсийг л хамгаалдаг. Гадна болон гадуур харуул хамгаалалт тавих шаардлаггүй байгууллагын хязгаарлагдмал гадна талбайг бүхэлд нь телехяналтаар харуул хамгаалалтыг зохион байгуулж байдаг.

Хүмүүсийг нэвтрүүлэх шалган нэвтрүүлэх цэгүүд нь хаалгатай хоёр блоклон хуваан тоноглогдсон өргөн коридор юм. Коридорын хана,

хаалгатай хуваалт нь сум нэвтэрдэггүй шилээр хийгдсэн байдаг. Хаалга нь нэгэн зэрэг нээх боломжгүй төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Хяналтын цэгийн орох хаалгыг цахилгаан механик цоожоор тоногдсон бөгөөд явган хүний коридорын хамгаалалтын хаалгыг хяналтын өрөөнд байгаа ажилтан нээдэг.

Тээврийн хэрэгсэл, ачааг шалгах зорилгоор шалган нэвтрүүлэх цэг дээр тээврийн хэрэгслийг шалгахдаа гэрэлтүүлэгтэй хазайсан толь, эсвэл видео камер, плазмын самбар бүхий бүр илүү орчин үеийн хувилбар, зүрхний цохилтод хариу үйлдэл үзүүлдэг тээврийн хэрэгслийг шалгах техникийн хэрэгсэл гэх мэт янз бүрийн төхөөрөмжийг ашигладаг.

Бүгд Найрамдах Франц улс

Франц улсын ял эдлүүлэх байгууллагын бүтэц нь:

1/ Мөрдөн тусгаарлах газар,

2/ Ял эдлүүлэх байгууллага гэсэн 2 төрөлд¹ хуваагдах ба ял эдлүүлэх байгууллага нь насанд хүрэгчдийн төвлөрсөн болон орон нутгийн хорих байгууллага, насанд хүрээгүйчүүдийн тусгайлсан сургалт, хүмүүжлийн байгууллагаас бүрдэнэ.

а) Төвлөрсөн хорих байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар ял эдлэгсдийн ялыг эдлүүлдэг. Шинээр ирсэн бүх хоригдлыг шоронгийн байдалд дасгахын тулд 45 хүртэлх хоног ганцаарчилсан тасалгаанд байлгадаг ба тэднийг засарч хүмүүжих төлвөө олсон, олоогүй, эргэлзээтэй байгаа гэж ангилдаг. Засрах төлвөө олсон хоригдлууд өдөр нь хамтарч ажиллаад, шөнө нь ганцаарчилсан тасалгаанд байрладаг байна. Засралын түвшин “сайн” гэж үнэлэгдсэн хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулах, хагас хөнгөн дэглэмд шилжүүлэн шоронгоос гадна ажиллах, төрөл төрөгсөдтэйгээ уулзах, хугацаанаас нь өмнө тэнсэн суллах гэх мэт урамшуулал үзүүлдэг байна.

б) Орон нутгийн засаг захиргаа өөрийн мэдэлд хорих байгууллагыг байгуулдаг бөгөөд тэр нь баривчлагдагсдын байр, хүмүүжлийн төв гэсэн ангилалтай байдаг. Орон нутгийн хорих байгууллагад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа яллагдагч, хор холбогдол бага эрүүгийн гэмт хэрэг үйлдэгчид, нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлэгчдийг хорьдог байна.

¹ Гантулга, Н. Хүний эрх ба хорих ял. 59 дэх тал. Уб. 2015

в) Насанд хүрээгүй хоригдлыг тусгайлан байгуулсан сургалт хүмүүжлийн байгууллагад байлгаж ялыг нь эдлүүлдэг.

Францын ял эдлүүлэх ажиллагааны нэг онцлог бол насанд хүрээгүй хоригдлыг шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг явдал юм. Нөгөө нэг онцлог нь Франц улсын шүүх хоригдлын эдлэх ялын хугацааг хасаж багасгах, тэднийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахад их өргөн эрх эдэлдэг байдал юм.

Францын ихэнх шоронд хяналтыг зохион байгуулахдаа хоригдогч, хоригдолуудыг ангилан ялгах зарчимд суурилдаг. Энэ зорилгоор янз бүрийн хөтөлбөр боловсруулагддаг байна. Жишээлбэл: Гэмт хэрэгтнүүдийг тодорхой онцлогоор нь хянах систем бөгөөд энэ нь тусгайлан бэлтгэсэн тест ашиглан, схемийн дагуу судалгаа хийж ангилдаг юм.

Хоригдол бүрийн хувьд дараахь шинж тэмдгүүдийг тусгасан тусгай картуудыг боловсруулсан: сэтгэл гутралын байдал байгаа эсэх; илрэл, хэт их түгшүүр, түрэмгий байдал; ичиж зовох эсвэл хэт ичимхий байдал; зан байдал, ярианд ер бусын зүйл байгаа эсэх; архи, мансууруулах бодисын нөлөөн дор байгаа зэрэг. Хоригдлуудад 24 цагийн турш хяналт тавих нь аюулгүй байдлын заавал биелүүлэх шаардлага гэж үздэг бөгөөд хамгаалалтын ажилтан нь хяналт тавьдаг. Хорих ангийн нутаг дэвсгэр дээр хоригдлуудын амь нас, аюулгүй байдалд заналхийлэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд алба хаагчид сонсогдохуйц газар байх, эсвэл дуудлага хийх хэрэгсэлтэй байх ёстой. Хоригдол бүрийг цагт нэгээс доошгүй удаа хяналт тавьж байх ёстой. Энэхүү шаардлагыг телехяналтын тусламжтайгаар гүйцэтгэдэг.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь “Ухаалаг хорих байгууллагын бий болгох” нь дэлхийн хамгийн аюулгүй хорих анги байгуулах, менежментийн цогц чадварыг сайжруулах чиглэлийг баримталж ирсэн байна. Тус чиглэлийн хүрээнд хууль сахиулах үйл ажиллагаанд хөдөлгөөнт терминал түгээмэл болсноор ухаалаг дагалдах хэрэгсэл, жолоочгүй хуяглан хүргэлтийн тээврийн хэрэгсэл, мэдээллийн системд анализ хийх гэх мэт ухаалаг программуудыг ашиглах, мэдээллийн санд задлан шинжлэх замаар хорих ангийн үйл ажиллагааг “үйлдлийн дараах арга хэмжээ”-с “үйлдлийг хийхээс өмнөх хяналт”-д, мэдээллийг боловсруулах системээс мэдээллийг урьдчилан

таамаглах, ээлжийн ажил хүлээлцэх менежментийг ухаалаг төхөөрөмжийн менежментийн хэлбэр рүү шилжүүлэх боломжийг бүрдүүлжээ. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хорих байгууллагад "Ухаалаг хорих байгууллага" төслийн хүрээнд дараах 14 системийг нэвтрүүлсэн байна. Үүнд:

Видео аналитик хяналтын систем - Видео шинжилгээний технологийг ашиглан хоригдогчдын хэвийн бус байдал, үйлдлүүдийг илрүүлэх.

Эрүүл мэндийн хяналтын систем - Цахим бугуйвч ашиглан хоригдогчдын зүрхний цохилт болон бусад бие байдлыг хянах.

Явах хөдөлгөөний хяналтын систем - Ухаалаг бугуйвч ашиглан хоригдогчдын өрөөнөөс гаднах хөдөлгөөнийг хянах.

Мансууруулах бодис мэдрэгч автомат роботын систем - Мансууруулах бодис болон бусад хориотой эд зүйл нэвтрэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор автомат робот үзлэг шинжилгээ хийх.

Цахилгаан цоожны аюулгүй байдлын систем - Албан хаагчдын нүүр царайгаар таньж үйлдэл үзүүлэх аюулгүй байдлын төхөөрөмж.

Байршлын мэдээллийн систем - Ухаалаг бугуйвч, нүүр таних технологийг ашиглан түр саатуулах байранд хоригдож байгаа хүний тоо, түүнчлэн тэдгээрийн бодит цагийн байршлыг байгууламжийн газарзүйн мэдээлэлтэй нэгтгэх;

Харилцаа холбооны нэгдсэн систем - Хоригдогч, харилцагч хоорондын утсан холбоо харилцааны үед дуу хоолойг илрүүлж зөвшөөрөлгүй гуравдагч этгээдийн оролцоог таслан зогсоох;

Түлхүүр ба тоног төхөөрөмжийн нэвтрэх систем - Түлхүүр, тоног төхөөрөмжийн менежментийг хөнгөвчлөхийн тулд /RFID /радио давтамжийг тодорхойлох технологийн ашиглана.

Хоригдогчдын цахим шүүгээ - Ухаалаг бугуйвчийг ашиглан еерсдийн эд зүйлс хадгалах шүүгээг түр хугацаанд эзэмших боломжтой.

Хоригдогчдын өөртөө үйлчлэх ТҮЦ машин - Ухаалаг бугуйвч болон өөрсдийн хувийн дугаартайгаа хослуулан хоол худалдаж авах, өргөдөл гаргах, хүсэлт гаргах, гэр бүлийнхэнтэйгээ харилцах зэрэг үйлчилгээг өөртөө үйлчлэх ТҮЦ машинаас авах боломжтой.

Хоригдогчдын бие даан суралцах таблет - Хоригдогчид планшетаар цахим ном унших, цахим сэтгүүл унших, хөгжим, видео үзэх гэх мэт өөртөө үйлчлэх;

Робот хяналтын систем - Хянагчийн эргүүл хийх тогтсон хугацааны хоорондох сул цагийн үед хоригдогчдыг биечлэн хянах

Ухаалаг хяналтын систем - Wifi, Bluetooth болон GPS технологид суурилсан ухаалаг бугуйвч ашиглан хорихоос өөр төрлийн ял, батлан Даалтад байгаа хоригдогчдыг хянах.

Албан хаагчдын гар төхөөрөмж - Албан хаагчдыг үүргээ гүйцэтгэх ажлыг хөнгөвчлөх, тэдний хоорондын харилцааг сайжруулах зорилгоор гар төхөөрөмжөөр буюу таблет.

Бүгд Найрамдах Польш Улс

БНПУ-ын хорих ангийн нэг онцлог нь хоригдогч болон нээлттэй, хагас нээлттэй, хаалттай дэглэмийн ялтныг байршлын хувьд тусгаарлалттайгаар нэг хорих ангид хорьдог ба Пиотрков, Трибуналски дахь шинэ хорих анги нь мөн тийм зохион байгуулалттай 700 хүний багтаамжтай, 400 хорих өрөөтэй, техник, технологийн орчин үеийн дэвшлийг ашиглан байгуулсан, өндөр стандарт бүхий хорих анги юм. Уг хорих ангийн үйл ажиллагаа, нөхцөл онцлогоос дурдвал:

-Хамгаалалтын 5,5 метр өндөртэй бетонон хашаа, 3 давхар торон хамгаалалт бүхий дотоод бүс дэх хашаатай, хамгаалалтын бүсэд дугариг хэлбэртэй, цаг агаарын ямар ч нөхцөлд бүх талаа хянах боломжтой, 8 метрийн өндөр харуулын цамхагтай.

-Хамгаалалтын хашааны хаалга бусад хонгил, жигүүрийн хаалга цахилгаан соронзон цоожтой, электрон түлхүүр нь тус тусдаа бүсийн хамгаалалтын бүрэлдэхүүний ахлагчид хадгалагддаг, 2 жигүүрийн буюу хонгилын хаалга нэгэн зэрэг онгойхгүй байхаар хийгдсэн,

-Хорих өрөөний хаалга, цонхны гадна, дотор давхар хамгаалалттай, хорих өрөөний хооронд харилцах боломжийг хаасан,

-Хяналтын төвийн тусгайлсан байранд 2 албан хаагч ажилладаг, хавтгай дэлгэц бүхий хяналтын дурангийн систем, бүх төрлийн утсан холбоонууд, мөн хорих өрөөний цэвэр ус, цахилгаан хамгаалалтын цоожны төвлөрсөн удирдлагыг нэг дор байрлуулсан,

-Хорих байр руу нэвтрэх хэсэгт металл илрүүлэгч хаалганаас гадна, хүний биенийг нэвт харах рентген төхөөрөмж суурилуулсан,

-Байнгын ажиллагаатай тусгай бүлэгтэй,

-Нийтийн гал тогоо, угаалгын байрыг тусад нь байрлуулж, үндсэн хорих байртай хонгилоор холбосон,

-Албан хаагчдын бэлтгэл сургалтад зориулсан спорт заал, бялдаржуулах танхим, урт болон богино бууны буудлагын механикжсан байртай,

-Алба хаагчид нь хамгаалалтын бамбай, тусгай хэрэгсэл, гаваар хангагдсан,

-Амиа хорлохыг завдсан, албан хаагчдад халдсан, хүч хэрэглэсэн, эсэргүүцэл үзүүлсэн хоригдогчийг тусгаарлах өрөөтэй зэрэг байдлаар орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан, аюулгүй байдлыг бүрэн хангасан хорих анги юм.

Канад Улс

1. Тусгай удирдлагын нэгж (SHU)

Тусгай удирдлагын нэгж нь Бүсийн хүлээн авах төв (RRC)-д байрлана.

Энэ нь Квебек мужид байрладаг олон дэглэм бүхий хорих байгууллага юм. Энэ нь аль нэг хорих байгууллага ямар нэгэн шалтгааны улмаас хоригдогчийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй байна гэж үзвэл энэхүү өндөр зохион байгуулалт бүхий байгууллагыг санал болгодог бөгөөд энэ байгууллага нь хүлээж авсны дараагаар аль болох богино хугацаанд өндөр хамгаалалт бүхий хорих анги уруу шилжүүлэхийг эрмэлздэг. Хоригдогч тухайн төвд хэдий хугацаагаар үлдэх нь бусад хоригдогчид болон албан хаагчид учруулж болзошгүй эрсдэлийн хэмжээ хэр зэрэг буурснаас шалтгаалах боловч энэ байгууллага нь хоригдогчийг дээд тал нь 90 хүртэл хоногоор байлгадаг.

2. Өндөр хамгаалалт бүхий хорих анги

Өндөр хамгаалалт бүхий хорих ангийн зорилго нь алба хаагчдад зориулан явуулсан тусгай сургалт, олгосон боловсрол зэргээр дамжуулан хоригдогчдыг дунд зэргийн хамгаалалт бүхий хорих анги уруу шилжих хэмжээнд хүртэл засрал хүмүүжил олгох явдал юм.

Өндөр хамгаалалт бүхий хорих байгууллага олон нийтийн аюулгүй байдалд өндөр эрсдэл учруулах магадлалтай гэж үзсэн хоригдогчдыг хорьдог бөгөөд ямар ч тохиолдолд оргох боломжгүйгээр өндөр харуул

хамгаалалт, хяналтын системийг суурилуулж өгсөн байдаг. Хоригдогсдын хөдөлгөөн, харилцаа холбоо, эрх чөлөө маш хязгаарлагдмал.

3. Дунд зэргийн хамгаалалт бүхий хорих

Дунд зэргийн хамгаалалт бүхий хорих нь хоригдогчдод өдрөөс өдөрт амьдралын утга учир, хариуцлагыг ойлгуулж, тэднийг илүү урам зоригтой болгоход нөлөөлж чадахуйц орчин нөхцөлөөр хангахад чиглэн ажилладаг бөгөөд өндөр хамгаалалт бүхий хорих ангийн нэгэн адил харуул хамгаалалттай байдаг.

Дунд зэргийн хамгаалалт бүхий хориход хоригдогчид хоорондоо харилцах, нэгэнтэйгээ найрсаг харилцах, нөхөрлөл үүсгэхийг зөвшөөрдөг явдал нь тухайн хоригдогчийг жирийн хамгаалалт бүхий хорих анги руу шилжих ажиллагааны бэлтгэл болж өгдөг юм.

4. Жирийн хамгаалалт бүхий хорих

Жирийн хамгаалалт бүхий хорих ангид цөөн тооны хязгаарлалт байдаг. Хөдөлгөөн, холбоо харилцаа болон хуулиар зөвшөөрөгдсөн зарим үйлдэл хийх нь үргэлж алба хаагчдын хяналтад байдаг ч чөлөөтэй бөгөөд аль болох бага хязгаарлалт хийхийг эрхэмлэдэг нь тэднийг эргэн нийгэмд ороход нь таатай нөхцөл, боломжийг олгодог гэж үздэг.

5. Эмэгтэй хоригдлыг хорих байгууллага

Эмэгтэй хоригдогчдын хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдэж эрүүгийн ял шийтгэгдсэн эмэгтэй ялтнуудад аюулгүй, тааламжтай орчин бүрдүүлэн ажиллахад чиглэн эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан засан хүмүүжүүлэх хөтөлбөр үйл ажиллагааг явуулдаг. Энэхүү хорих байгууллагад өндөр хамгаалалт бүхий, дунд зэргийн хамгаалалт бүхий, жирийн хамгаалалт бүхий бүх харуул хамгаалалтын дэглэм бүхий байгууламж байдаг. Окахами Очид жирийн болон дунд зэргийн хамгаалалт бүхий хорих анги байдаг. Эмэгтэй хоригдогчид өөрсдийн харуул хамгаалалтын дэглэмээр ангилагдан өөр өөр хэсэгт ял эдэлдэг. Жирийн болон дунд зэргийн хамгаалалт бүхий байгууламж нь хамтдаа байдаг бөгөөд тэдгээр ялтнууд хоол, угаалга хийх болон өдөр тутмын ажлыг хуваарийн дагуу хийх үүрэгтэй байдаг.

Эмэгтэйчүүдийн ангиллын хамгийн дээд нь өндөр хамгаалалт бүхий хорих анги бөгөөд тэнд хоригдох эмэгтэй ялтан өндөр харуул хамгаалалтын нөхцөлд ял эдэлнэ. Канад улсын хорих байгууллага нь нэгд, төрийн алба

хаагчдын аюулгүй байдал, хоёрт, байгууллагын аюулгүй байдал, гуравт, нийтийн аюулгүй байдалд ихээхэн анхаарч ажилладаг.

1. Алба хаагчдын аюулгүй байдал.

Канадын хорих байгууллага бүх ажилтнуудын аюулгүй ажиллах орчинг бүрдүүлж сургалт, тоног төхөөрөмжөөр алба хаагчдыг тогтмол хангаж ямар ч хүнд, хэцүү нөхцөлд ажиллахад бэлэн байлгахыг зорьж ажилладаг.

Канадын хорих байгууллагад өдөр тутамд албан үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын хэд хэдэн арга хэмжээг авч ажилладаг.

Хамгаалалтын хувцас, тоног төхөөрөмжийн стандарт бүр нь ажилтны ажил үүргээ гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангаж байх ёстой гэж үздэг.

Хамгаалалтын хантааз: Тусгай удирдлагын нэгж, өндөр хамгаалалт бүхий, дунд зэргийн хамгаалалт бүхий хорих анги, эмчилгээний төв болон эмэгтэйчүүдийн хорих байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ заавал өмсөхийг шаарддаг.

Хамгаалалтын бээлий: Бүх хорих ангийн алба хаагчид хэрэглэнэ. Энэ нь нэгжлэг хийж байх явцад хуруу гараа эсгэх, бие махбодод хор учруулах шингэн бодис зэргээс хамгаалдаг.

Гарын гав: Хоригдолтой шууд харилцдаг аливаа албан хаагчид биедээ авч явахыг шаарддаг.

Шүршигч: Өндөр болон дунд зэргийн хамгаалалт бүхий хорих анги, эмчилгээний төв, эмэгтэйчүүдийн хорих байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ заавал биедээ авч явна.

Маск: Хорих ангийн алба хаагчийн үүргийн нэг болох яаралтай анхан шатны тусламж үзүүлэх шаардлагатай үед хэрэглэх зорилгоор хорих ангийн байранд болон албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд болон албаны тээврийн хэрэгслээр явж байхдаа биедээ авч явна.

Сургалт: Канадын хорих байгууллагын алба хаагчдад маш олон төрлийн сургалтын агуулга бүхий үнэмлэх олгох, мөн хугацаа сунгаж дахин үнэмлэх олгох сургалтад хамрагдана. Энэхүү сургалтад хиймэл амьсгал хийх, ялтантай хэлэлцээ хийх стратеги, галт зэвсэг хэрэглэх болон

хяналтаар хангах аргачлал гэх мэт агуулгаар хичээл заахаас гадна ажлын байран дахь тулгарч болзошгүй аюул, бусад албан хаагч, хоригдогчоос ирж болох дарамт, хүчирхийлэл, ялтны амиа хорлохыг завдах зэрэг зөрчилдөөний асуудал тулгарвал хэрхэн бэлтгэлтэй байх талаар заадаг.

Үндэсний хяналтын төв: (NMC) Үндэсний Хяналтын төвийн үйл ажиллагааг Үндэсний Төвийн бүсийн байгууллага хариуцан явуулдаг бөгөөд хоригдогчид, албан хаагчид, бусад олон нийтийн болон төрийн байгууллагыг аюулгүй байдлаар ханган ажилладаг. Ажлын цагаар NMC буюу Үндэсний хяналтын төв нь алба хаагчдын аюулгүй байдлыг хангаж, тэдний үйл ажиллагааны мэдээг хянадаг. Ажлын цагийн дараа хоригдогчдын гомдол мэдээллийг шалгах, тэдэнд шаардлагатай тохиолдолд яаралтай тусламж үзүүлдэг.

2. Байгууллагын аюулгүй байдал

Канадын хорих байгууллага нь ажилтнууд, хоригдогчид болон тэдний гэр бүлийн гишүүд, бусад зорилгоор хорих анги дээр ирэх аливаа этгээдийн хувьд аюулгүй, найдвартай орчинг бүрдүүлж, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж ажилладаг. Мөн түүнээс гадна хоригдогчдыг аюулгүй, тайван орчноор ханган, тэдний зан үйлийг өөрчлөхөд анхаарлаа хандуулж хуулийг дээдэлдэг иргэн болгон нийгэмд буцан оруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Хар тамхи, мансууруулах бодисын судалгаа шинжилгээ болон урьдчилан сэргийлэх: Канадын хорих байгууллагын нэн тэргүүний асуудал бол хар тамхины гэмт хэргийг бууруулж, урьдчилан сэргийлэх явдал юм. Ийм учраас улсын хэмжээний хар тамхины хайгуулын бүхий л үйл ажиллагааг Канадын хорих байгууллага ханган ажилладаг. Алба хаагчид, гэрээгээр ажиллагсад, зочид, сайн дурынхан гэх мэт хүмүүсийг металл илрүүлэгч, ION сканер (эм илрүүлэх), рентген машин, мансууруулах бодис илрүүлэгч нохой зэргийг ашиглан шалгадаг.

Аюулгүй байдлын алба: Аюулгүй байдлын програм нь Канадын хорих байгууллагын мэдээллийн сүлжээний зүрх юм. Энэхүү програмын тусламжтайгаар хамтран ажилладаг олон улсын, орон нутгийн байгууллага болон агентлагтай мэдээлэл солилцож, мөн мэдээлэл хүлээн авдаг. Ингэснээр хорих байгууллагын салбар, нэгжийг цаг тухайд нь удирдлагаар хангах, тэдэнд үнэн зөв холбогдох мэдээллийг олж өгөх, тулгарч болох

эрсдэлээс урьдчилан сэргийлж, стратегийн шийдвэр гаргах боломжийг олгодог.

Тусгаарлалт: Хоригдогчдын аюулгүй байдлыг хангах үүднээс тэднийг ангилан өрөөнүүдэд оруулсан байдаг. Энэ нь хорих байгууллага дотор ял эдэлж байгаа, бусад этгээдүүдээс тэдний эрх ашиг, хууль ёсны эрхийг хамгаалах зорилготойгоор хийгддэг. Тусгаарлагдсан хоригдогч бусад хоригдогчдын адил хууль ёсны шаардлага тавих, аюулгүй байдлаа хангуулах болон бусад эрхийг эдэлнэ. Тусгаарлагдсан хоригдогчийг хувь хүн, алба хаагч, зочид болон бусад хоригдогч, байгууллагад гэм хор учруулахгүй гэж үзсэн үед тусгаарлах өрөөнөөс гарган бусад хоригдогчидтой хамт байлгаж болно.

Хоригдогчдын эд зүйл: Хорих ангийн харуул хамгаалалтын дэглэмийн түвшинөөс шалтгаалан тэдний өрөөндөө байлгахыг зөвшөөрсөн эд зүйл нь өөр өөр байна. Нийтийн, алба хаагчдын, хоригдогчдын болон хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор өөрийн эд зүйлсийг биедээ авч явах, бусдад дамжуулахыг хориглох бөгөөд зөвшөөрөгдсөн эд зүйлсийг аливаа хоригдогчид зөвхөн өөрийн өрөөндөө байлгана.

3. Нийтийн аюулгүй байдал

Олон нийтийн байгууллагатай хамтарсан засан сайжруулах ажиллагааг явуулах зорилгоор байгуулсан төв ажилладаг. Тухайн үйл ажиллагааг тогтмол явуулдаг алба хаагчдыг 24 цагийн хяналтад байлгаж тэдэнд ажил, үүргээ явуулах боломжийг олгодог. Учир нь тэд бол хорих байгууллага болон нийгмийн хооронд харилцах гол гүүр болдог бөгөөд хоригдогч ялын хугацаа дуусаж суллагдан нийгэмд орох үед засрал олоход аажмаар нөлөөлөн тусалдаг чухал хүчин зүйл болж чаддаг.

Канадын хорих байгууллагад ирж буй хүмүүс заавал дагаж мөрдөх ёстой хэд хэдэн журам байдаг. Эдгээр журмууд нь хоригдогчид, албан хаагчид ялангуяа хорих ангид гаднаас ирж буй хүмүүсийн аюулгүй байдлыг хангах зорилготой юм.

Хорих байгууллагад орох: Аливаа хорих ангид орж байгаа хүмүүс өөрсдийн түрийвч, тамхи, цүнх, гар утас, бичиг баримт, цаасан материал, болон бусад электрон төхөөрөмж гэх мэт биедээ авч яваа болон авчирсан бүхий л зүйлийг үлдээх ёстой. Дотогш орсны дараа албан ёсны фото зураг бүхий бичиг баримтаа шалгуулж, ялантай уулзахаар ирэгчдийн бүртгэл,

албаны ажлаар хорих ангид орохыг хүсэгчдийн бүртгэл гэсэн 2 төрлийн маягтаас өөрийн зорилгын дагуу бөглөх шаардлагатай болно. Үүний дараагаар металл илрүүлэгч болон хар тамхи, мансууруулах бодис илрүүлэгч ION сканераар шалгуулдаг журамтай байдаг. Канад улсын хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилт нь Монгол улсын нөхцөлд тохирох эсэх талаар цаашид судлах шаардлагатай болох нь дээр дурдсан илтгэлийн агуулгаас харагдаж байна.

АНУ-ын Нью-Йорк мужийн Оборн хотод 1816 онд ял эдлүүлэх байгууллага бий болж ганцаарчлан хорих ял эдлүүлэх, нөгөө талаар хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх, эдийн засгийн хувьд ашигтай байх шинэ үзэл санаагаар ажиллаж эхэлснээр энэхүү ял эдлүүлэх ажиллагааг “Оборны хэлбэр” хэмээн нэрлэгдэж одоо ч голлох байр суурийг эзэлдэг ба европын болон ази номхон далайн улс орнуудад дэлгэрсэн онцлогтой. АНУ-ын шоронгуудад “Пеннсилвани” болон “Оборн” системийн хатуу тогтоогдсон дэглэм журам, дэвшилтэт хэлбэрийн аль аль нь үйлчилдэг. АНУ болон Ази-Номхон далайн улсуудын хорих ял эдлүүлэх дэглэм нь европын холбооны улсуудын адил нээлттэй, хаалттай дэглэмээс бүрдэх боловч онц аюултай гэмт хэрэгтнийг хорьж ялыг нь эдлүүлэх тусгай хорих анги /шорон/ тэдгээрийн харуул хамгаалалт хяналтын 3-5 зэрэглэлтэй байдаг онцлогтой.

Швед Улс

Швед Улсын Стокгольм хотоос холгүй орших Кумла гэх хорих байгууллагыг судлан авч үзье. Хяналтын цамхаг байдаггүйгээрээ энэхүү хорих байгууллага нь онцлогтой. Хэрмэн хашааг төмөр тортой бөгөөд хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгчийг суурьлуулсан байдаг. Хөдөлгөөн мэдрэгчид ойртох оролдлого хийхэд л тусгай дохио ажиллаж эхэлдэг байна. Бүхий л хэсэгт камерын хяналттай, тэр дундаа гал тогоо, спорт заал, үйлдвэрлэлийн хэсэг зэрэг. Хорих байгууллагын бүх байгууламжид камерын хяналт заавал байх ёстой бөгөөд хяналт тавих, хүний эрхийг хангах зорилготой байна. Нэг талаасаа, өөрсдийн камераас (өрөө) гадна байхдаа хоригдлууд байнгын хяналтад байдаг, нөгөө талаас тогтмол бичлэг хийгдэж байдгаас хамгаалалтын ажилтнууд өөрсдийгөө зөв авч явах шаардлагатай болдог байна. Аюултай гэмт хэрэгтнүүдийг хорих, дэглэмийг хүндрүүлэх зорилгоор Шведийн гурван хорих байгууллагын хэсэгт “бункер”-ыг барьсан бөгөөд өөрөөр хэлбэл тэндээс оргох ямар ч боломжгүй юм. Бункер нь шоронгуудад хамгаалалтын ажилчидтай шууд харьцах

боломжгүй бөгөөд өөр хоорондоо заримдаа л харьцдаг байна. Богино хугацааны салхилалтыг хаалттай хэсэгт зохион байгуулдаг бөгөөд бүх хөдөлгөөнийг газар доогуур хийж техник хэрэгслийн тусламжтайгаар тогтмол хяналтыг тавьдаг.

Дээр дурдсан зүйлийг дүгнэж хэлэхэд гадаадын улс орнуудын урьдчилан хорих ангиудад хяналтын зохион байгуулах талаархи баялаг, олон янзын туршлагыг тэмдэглэх шаардлагатай байна. Жишээлбэл дээр дурьдсан Швед Улсад) алба хаагчид болон хоригдол, хоригдогчдын тооны харьцаа бараг 1:1-ийн харьцаатай байдаг бөгөөд Монгол Улсын хорих ял эдлүүлэх байгууллагуудад ээлжийн харуул хамгаалалтын ажилтны харьцаа 100 хоригдолд 2-3, 30-35 хоригдогч 1 хамгаалалтын ажилтан байгаа юм.

Сингапур улс

Сингапурын хорих байгууллагын нэвтрүүлсэн аюулгүй байдлын систем нь бүх хоригдогчдын суурь, нэгдсэн, бие даасан байрны систем юм. Тус систем нь хоригдогчдын "Амьдрах байрны хэсэг" голчлон чиглэгдсэн бөгөөд хоригдлуудын бие махбодын болон динамик аюулгүй байдлыг хангах, тэдэнд учирч болох эрсдэлийг, харилцан адилгүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй зохион явуулах зориулалттай байгуулсан байна.

Мөн тус системийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох "Хянагчгүй хорих байгууллага" хөтөлбөрийг хэрэгжилтийг сайжруулахад дэвшилтэт технологийг ашигласан. Техник, технологийн дэвшлийг ашигласнаар өдөр тутмын энгийн ажлыг автоматжуулж, албан хаагчдад нарийвчилсан, Дараагийн төвшний ажлыг гүйцэтгэх боломжийг олгох бөгөөд хоригдогчийг засан хүмүүжүүлж, нийгэмшүүлэх арга хэрэгслийг дижитал хэлбэрт шилжүүлэх (DIRECT), хорих байгууллагын үйл ажиллагаа, засан

Хүмүүжүүлэх системийн хөдөлгөөнт төхөөрөмж (M-PORTS) зэрэг хоёр төслийн нэвтрүүлжээ.

Эх сурвалж:

Richard Tewksbury. Prisons in the Last Ten Years, Victims & Offenders, DOI: 10.1080/15564886.2010.485905 .PP. 242-243. (2010)

Гантулга, Н. Хүний эрх ба хорих ял. 59 дэх тал. УБ. 2015.

Пүрэвсүрэн, О. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ. 2014.

---o0o---